

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 12-ны өдөр

Дугаар

БА-015/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 10 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 4 давхар 1 блок хүчин чадал бүхий хорооны цогцолборын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 10 сарын 02-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/02/13 огноо, 0014492 дугаар, БАЗГ-2024/0054

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ТК/20/09/30

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 23-р хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилгын "Б" блок 5 давхар, 11-324249 холбоо барих утас;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Энх бизнес өгөөмж ХХК оноосон нэр, 9011487023 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5844568 регистрийн дугаар, БУ18-661/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо, 6-р хороолол бумцэнд 47/б, 99103036 холбоо барих утас;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Ланд бимион ХХК оноосон нэр, 9011767011 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6350232 регистрийн дугаар, ЗТ19-75/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17-р хороо, сурагчийн 81, 961 тоот 99996305 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар оноосон нэр, 9070002085 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9088822 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

хот, Баянгол дүүрэг, замчдын гудамж 3,4-р хороо, БГД-ийн ЗДТГ-ын төв байр, холбоо барих утас 70123143, 70126999

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 4 давхар 1 блок хүчин чадал бүхий хорооны цогцолборын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивд, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

ХУВАЛТ ШАЛГ
ГАЗАР
Барилга байгууламжийг
орлуулах ко


3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьтой 4 давхар 1 блок хүчин чадал бүхий хорооны цогцолборын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ-ийн захиалгатай, зоорьтой 4 давхар 1 блок
хорооны цогцолборын барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч





(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газрын Барилга захиалагчийн хэлтсийн дарга



(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 10 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 4 ДАВХАР 1 БЛОК
ХОРООНЫ ЦОГЦОЛБОРЫН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 10 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 4 давхар 1 блок хорооны цогцолборын барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 4 дүгээр давхарт 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр 11:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 13:00 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|--|---|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс
О.Оджаргал |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлстийн дарга | Б.Ганзориг |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч | Ж.Жүгдэрмаа |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер | Ц.Цэрэннадмид
Э.Ундрахцогт |
| 6. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ахлах инженер | |
| 7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологи удирдлагын төлөвлөлтийн газрын чанар Хяналтын хэлтсийн мэргэжилтэн | Ц.Дагвадорж |
| 8. Ус сувгийн удирдах газрын хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер | Г.Үүрийнгэгээ |
| 9. Нийслэлийн Онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төсөл хяналтын ахлах байцаагч, хошууч | Б.Даваасүрэн |
| 10. Үндэсний Төв архив, зураг төслийн баримтын Архивч | Б.Оюунжаргал |
| 11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын Хэлтсийн мэргэжилтэн | Ж.Батсайхан |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага | Н.Эрдэнэтөгс |
| 13. Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын Төлөвлөлт гүйцэтгэлийн хэлтсийн дарга | Г.Энхцэнгэл |
| 14. Ланд бимон ХХК-ийн архитектор | Г.Ууганбаяр |

15. Энх бизнес өгөөмж ХХК-ийн
гүйцэтгэх захирал

Батзориг

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зоорьтой 4 давхар 1 блок хорооны цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гарга в.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын Улсын байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Барилгын хийцийн давхар бүрт бетоныг шинжлүүлсэн лабортоорын дүгнэлт хянуулах.
- Дээврийн хашлага, хана салхивчын сувагт өгсүүлсэн хар цаасыг ховилдож зурагт заасны дагуу гүйцэтгэсэнг хянуулах
- Өрхийн эмнэлэгийн үүдэнд буюу зүүн хойд талын хаяавч өндрийн зөрүүтэй байгааг зураг төсөв зохиочтой хамтран ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангуулж хянуулах
- Хороонд барилгын хувийн хэрэг нээж, зураг, төсөв бичиг баримтыг хүлээлгэж, ашиглалтын дүрмийн дагуу ашиглах, хувийн хэргийг хөтлөж хэвших

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулаан, цэвэр усны худаг норм стандартад хийцүүлэн угсралтын ажил хийх.
- Борооны ус зайлуулах шугамын угсралт доошлуулах
- Үзелд хаягжуулалт
- Ариун цэвэр болон давхарт бүрт угсрагдсан агаар сэлгэлтийн механик системийн дууг багасгаж хэвийн болгох
- Давхруудын угаалтуурын сифон хоолойн битүүмж зайжруулан хэвийн болгох
- Бохир усны / 00 өрөөнд/ шугам далдалж хаалт хийх
- Гадна дулааны батлагдсан зураг шалгуулах, мөн гадна дулаан ус хангамжын ил далд, сорилт туршилтын акт хангагч байгууллагаар батлуулах
- Халаах хэрэгсэлд термостат хаалт хийх
- Ундны усныг шинжилгээнд хамруулан эрүүл ахуйн улсын байцаагчын дүгнэлт гаргуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Бар

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, ахлах инженер **Э.Ундрахцогт**:

- ОСНААУГ- тай хүлээлцсэн акт үзүүлэх.
- Гадна дулааны батлагдсан зураг нөхөж шалгуулах
- Гадна дулааны худаг цэвэрлэж худаг доторх шугамууд будаж, дулаалах, хүн орж гарах чөлөөтэй болгох
- Холимог нацосын температур тохируулах, автоматын гадна агаарын дачик суурилуулж ажилд оруулах
- Холигч нацосны үзелийн дулаалга гүйцээж хийх
- Халаах хэрэгсэлүүдэд термостат хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологи удирдлагын төлөвлөлтийн газрын чанар Хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Ц.Дагвадорж**:

- Дотор холбоо дохиололын ажлыг актаар баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах.

Ус сувгийн удирдах газрын хэрэглэгчдэд үйлчлэх төвийн инженер **Г.Үүрийнгэгээ**:

- ОСНААУГ-ын 78/2020 тоот техникийн тодруулга, УС-ын 691/20 тоот техникийг нөхцөлд схемн өөрчлөлт хийсний дараа цэвэр усны холболт хийх тодруулга, тайлбар албан бичиг авч шалгуулах
- Гадна цэвэр бохир усны шугамын угсралтын үеийн ил далд ажлын актыг хүт 13 -ын холбогдох ажилтангаар хянуулж баталгаажуулах
- Гадна бохир усны нэг худаг дутуу угсарсан тайлбар ирүүлэх
- БУХ- ын лаг шаврыг авч лайдаж цэвэрлэх, ул цутагсан эсэх фото акт шалгуулах, дулаалгын давхар хийх
- ОСНААУГ -тай байгуулсан гэрээнд тамга байхгүй тул хүчин төгөлдөр мөн эсэх нотлох бичиг баримт үзүүлэх
- ОСНААУГ тай гэрээгүй бол хэргэлсэн усны төлбөр тоолуурын заалтаар төлөх, тоолуурын лац тасарсан тул баталгаажуулж гэрчилгээг шалгуулах
- Ундны усны сорьц өгч дүгнэлтийг шалгуулах /нян, хими, физик
- Холболт хийх шугамын голч багассан тайлбар ирүүлэх
- Дээврийн ус зайлуулах шугамыг доош буулгах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ, Техник хяналтын инженер **Ц.Цэрэннадмид**:

- Гүйцэтгэлийн актад гарын үсэг бүрэн баталгаажуулах
- ЕОС, ХС -хаяг бичиглэл хийх, схем байршуулах, АА- ын плакат хадах
- АВР-ын самбарын тоолуурын холболт буруу байгаа тул БГ-ХҮТ -д захиалга өгч засуулах
- Гадна цахилгааны угсралт хийсэн Хустайн шил ХХК-ын тусгай зөвшөөрөл үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

ХЯНАЛТ
Г

лга байгуул
оруул

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төсөл хяналтын ахлах байцаагч, хошууч Б.Даваасүрэн:

- Гадна дулаалгын дүгнэлт нөхөж үзүүлэх
- Галын тохиололын систем батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэлтэй зураг хийх
- Дотуур даралтад усны цэг холбох, хомут солих, тэмдэглэгээ байршуулах
- Гал унтраах багаж, зэвсэглэмж байршуулах, MNS :2020 стандартын дагуу
- Дээвэрт гарах шат зургын дагуу хийх, хамгаалалт хийх
- 2 дугаар давхраас 1 дүгээр давхарт буух, гарах хэсгийн шатны марш засах, хаалт хийх
- Цахилгааны ерөнхий шитний өрөөнд бие даасан автомат гал унтраах модулын систем төлөвлөх
- Серверийн өрөөнд металл хаалга хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний Төв архив, зураг төслийн баримтын архивч Б.Оюунжаргал:

- Архивд хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, баримт бичгийн хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Ажлын зургийг зургийн бүрдлийн дагуу бүрэн бүрдэлтэй төрөлжүүлж нүүр хуудас хийн, хуудас дугаар
- Ажлын Барилгын хувийн хэрэг жагсаалтын дагуу зөв дараалан бүрэн бүрдэлтэй өгөх
- ИГС дүгнэлт эх хувиар тусд нь бүрдүүлж өгөх
- БУ-ын ил далд акт, гэрэл зургийг ажлын дарааллаар бүрэн баталгажуулж эх хувиар өгөх
- БУ-ын ажлын тэмдэглэл дэвтэр эх хувиар баталгажуулж авах
- Магадлалаар орсон эх хувь төсөв тусд нь үүсгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Барилга хөгжлийн төв, Норм нормативын хэлтсийн мэргэжилтэн **Ж.Батсайхан**:

- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна тохижилт, ногоон байгууламж, явган хүний зам сандал, саравчыг хийж дуусгах
- Дээврийн хар цаас хөндийрсөн хэсгийг засаж сайжруулах
- 1 дүгээр давхраас 2 дугаар давхарт гарах хэсгийн эргэлтйн цэгээс дээш бариул талд байрлах талбайд хаалт хийж гүйцэтгэх
- Дээврийн ус зайлуулах хоолойг доош буулгаж өгөх
- Барилгын зүүн хойд хэсэгт байрлах барилгын хаяавч болон хөрсний эко хавтан уулзах хэсгийн газрын өндөржилттэй хэсэгт хашлага хаалт хийж өгөх
- Норм нормативийн санд нормчлалын сангийн төлбөрийг төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс**:

- Гаднах үүдний довжооны пандусны налуулгыг батлагдсан зургын дагуу налуулга мөн 2 талд нь ижил хэмжээтэй бариулыг стандартын дагуу хийх

- Батлагдсан зургын дагуу ХБИ -д зориулсан ариун цэврийн өрөөнд суултуур болон угаалтуур стандартын дагуу тоноглох, мөн 1, 2 дугаар давхарт нэмэлтээр хийж гүйцэтгэх ариун цэврийн өрөөний хаалтыг авах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газрын Төлөвлөлт гүйцэтгэлийн хэлтсийн дарга **Г.Энхцэнгэл:**

- Барилгын дээврийн хар цаас зарим газраа овоосон хэсгийн засах
- Дээврийн хонгил с орж ирж буй хэсэгт довжоо марш шат хийх
- Ариун цэврийн/ эмнэлэгийн / ХБИ -д зориулсан бариул хийх
- Хорооны гадна хаалганы хойд хэсгийн хүн зорчих хэсгийг нээж шат байрлуулах
- Баруун хойд талд хийсэн сүүдрэвчийн 3 талд хашлага хийх
- Барилгын зүүн хойд талын урагшаа байгаа налууд хашлага хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Ланд биомон ХХК-ийн Архитектур **Г.Ууганбаяр:**

- хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан гадна шатанд бариул хийх
- Ариун цэврийн өрөөнүүдэд ХБИ -д зориулсан тоноглол суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч, Энх бизнес өгөөмж ХХК-ийн гүйцэтгэх захирал **Батзориг:**

- Нийт гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлтсийн дарга **Э.Орхонсэлэнгэ:**

- Цахилгааны шитны өрөөнд шитны газардуулгыг дахин хийж шалгуулах, бусад шитүүдийг газардуулах хэсэгт холбох / Узель болон лифтны өрөөнүүд/
- ХТП-923-аас ирсэн кабелийн үзүүрт бичлэг бирк хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- Барилгын норм дүрэм 11-04-16 дагуу зохиогчийн дүгнэлт бичих
- Барилгын тухай хуулийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх
- Дээврийн цонхы амалгааг дуусгах
- Батлагдсан зураг төсвийн дагуу гадна тохижилт, ногоон байгууламж хийж гүйцэтгэх
- Хар цаас хавгасан бүрэн засварлах
- Аваарын гарцны вакум хаалгыг металл хаалгаар солих, 2- с 1 дүгээр давхар луу буух шатны хэрэглээг тодорхойлох
- Шатны хонгилын шатны зайг битүү болгох

ЛТЫН

ашиглалт
с

- Гадна налуу замыг барилгын баруун урд булан хүртэл үргэлжлүүлэх
- Дээврийн ус зайлуулах хоолойг доош буулгах
- Дутуу ажлын бүрэн дуусгах үүнд: Хүүхдийн тоглоомын талбай/ хашаатай/ , - Шат хийх өндөржилт, -Ногоон байгууламж , - авто зогсоолын тэмдэг тэмдэглэгээ

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зоорьтой 4 давхар 1 блок хүчин чадал бүхий хорооны цогцолборын зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын,
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын
газар, барилга захиалагчийн хэлтсийн
дарга



(Б.Ганзориг)

ганд